



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ.
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
/Албан тушаал/



А.ЭНХМАНЛАЙ
/Гарын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 28

Дугаар 35-00/06

Улаанбаатар хот

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт
хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл:

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн 2025 оны 06/18946 дугаар албан бичгийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022-2024 онуудад тусгай хамгаалалттай газар нутагт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулсан байдлыг хянаж шалгах Төрийн хяналт шалгалтын тухай, Газрын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр:

2.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /тухайн үеийн нэрээр/, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар, Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанууд тус тус хамрагдана.

2.2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022-2024 онуудад тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийн дагуу газар олголт хийсэн эсэх.

2.3. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар ашиглуулсан эсэх.

2.4. Газар ашиглах гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх.

1535080020

2.5. Төсөл сонгон шалгаруулалтын зарчмын дагуу газар ашиглуулах шийдвэр гаргадаг эсэх.

2.6. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах гэрээг дүгнэдэг эсэх.

Гурав. Шалгалтын төрөл, арга:

3.1. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийнэ.

3.2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харъяа тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаануудад хадгалагдаж байгаа нэгж талбарын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг хянан үзэх, баримт бичгийг гаргуулан авах, шаардлагатай тохиолдолд дүрс бичлэг хийх зэргээр хийж гүйцэтгэнэ.

3.3. Шаардлагатай баримт бичиг, холбогдох судалгаа, мэдээллийг шалгуулагч байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зуруулах, хуулбар үнэн даруулах зэргээр нотлох баримтын шаардлага хангуулан хуулбарлан авна.

Дөрөв. Шалгалт хийх бүрэлдэхүүн:

4.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн дарга Д.Түвшинбат ахалж, Газар, геодези, зураг зүйн улсын ахлах байцаагч Г.Энхтулга, Г.Энхжин, Газар, геодези, зураг зүйн улсын байцаагч Т.Эрдэнэболор, Б.Туул, Ц.Пагмадулам, Э.Юмжирмаа, Э.Амаржаргал нар хийж гүйцэтгэнэ.

4.2. Шаардлагатай тохиолдолд бусад хэлтсийн холбогдох (ахлах) мэргэжилтэнг татан оролцуулж болно.

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа:

5.1. Шалгалтыг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шалгалтын дүнг танилцуулах:

6.1. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын танилцуулгыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын нийтлэг журам”-ын 25 дахь хэсэгт заасны дагуу нэгтгэж холбогдох газарт хүргүүлж ажиллана.